

БНХАУ-ын цаг уурын байгууллагаас зохион байгуулсан “Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх олон улсын зайн сургалт 2022” сэдэвт олон улсын цахим сургалтад хамрагдсан товч тайлан

Улаанбаатар

2022.04.22

Нислэгийн цаг уурын өртөөний инженер З.Буян-Өлзий 2022 оны 04 сарын 13-наас 22-ний хооронд БНХАУ-ын Цаг уурын байгууллага (СМА)-аас ивээн тэтгэж, БНХАУ-ын Цаг уурын сургалтын төв (СМАТС), ДЦУБ-ын Бээжин дэх бүсийн сургалтын төв (RTC-Beijing)-өөс зохион байгуулсан “Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх олон улсын зайн сургалт 2022” сэдэвт олон улсын алсын зайн цахим сургалтад хамрагдсан.

Энэхүү олон улсын сургалтын зорилго нь: Сургалтад хамрагдсан суралцагч нарт уур амьсгалын өөрчлөлт, түүний шинжлэх ухааны үндэслэл, үүсгэн бий болгож буй хүчин зүйлүүд, дэлхий болон ан амьтан, хүнд шууд болон шууд бусаар нөлөөлөх нөлөөлөл, тэдгээрийн үр дагавар, үүссэн болон ирээдүйд үүсэж болох нөхцөл түүнд уялдуулан авах арга техникийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой.

Уг сургалтыг БНХАУ-ын цаг уурын байгууллагын сургалтын төвийн доктор, профессор багш нар удирдан чиглүүлж, шууд хичээл, РРТ болон видео хичээлүүдээр хүргэсэн бөгөөд Америкийн нэгдсэн улс, Алжир, Арабын Нэгдсэн Эмират Улс, Армени, Аргентин, Бахрейн, Бахам, Беларусь, Бүгд Найрамдах Бурунди Улс, Бутаны Хаант Улс, Бразил, Бүгд Найрамдах Ардчилсан Йемен Ард Улс, Боствана, ӨАБНУ, Бүгд Найрамдах Замби Улс, Гана, Габон, Индонези, Иран, Испани, Казакстан, Камерун, Кени, Коста Рика, Конго, Мексик, Мадагаскар Улс, Малайз, Малави, Мароккогийн Хант Улс, Монгол, Намиб Нигери, Орос, Пакистан, Руанда, Румын, Судан, Сейшелийн арлууд, Тайланд, Танзани, Узбекистан Украин, Филиппин, Бүгд Найрамдах Фижи, Хондурас Улс, Шинэ Зеланд, Зимбабве, зэрэг нийт 47 орны 200 гаруй оролцогч хамрагдсан.




Зураг №1

Сургалтыг Хятадын цаг уурын шинжлэх ухааны академийн доктор ZHAI Panmao “Дэлхийн цаг уурын өөрчлөлтийн шинжлэх ухааны баримтууд ба IPCC-ийн ажлын хэсгийн хүрээнд явагддаг үйл ажиллагааны талаар танилцуулсан.

Сургалт нь: 6 бүлэгтэйгээр дараах сэдвүүдийн хүрээнд явагдсан. Үүнд:

- Хичээлийн агуулга, танилцуулга;
  - Оролцогчид өөрийн танилцуулгуудаа илгээсэн.
- Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх шинжлэх ухааны барим болон дүгнэлтүүд;
  - Дэлхийн цаг уурын өөрчлөлтийн шинжлэх ухааны баримтууд;
  - Цаг агаарын аюултай үзэгдлийн хяналт;
  - Өнгөрсөн хугацааны цаг уурын өөрчлөлт: CO<sup>2</sup>-оос үүдэлтэй хамгийн их дулаарал (PETM)-ын жишээ судалгаа;



- Уур амьсгалын өөрчлөлтийг удаашруулах, дасан зохицох технологи ба практик;
  - Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, дасан зохицох чадвар, эмзэг байдал;
  - Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн менежмент ба гамшгийн бэлэн байдал;
  - Нүүрстөрөгчийг саармагжуулах зорилт бүхий Хятадын эрчим хүч, эдийн засгийн шилжилт;
  - Уур амьсгалын өөрчлөлт ба хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил;
  - Форум: Уур амьсгалын өөрчлөлтийн улс оронд үзүүлэх нөлөө, эсрэг арга хэмжээ (Эдийн засаг, эрчим хүч, аж үйлдвэрийн бүтэц, экологийн орчин);
- Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, үйл ажиллагаа;
  - Дэлхийн уур амьсгалын бодлого ба уур амьсгалын талаарх олон улсын үйл ажиллагаа;
  - NWP загвар дахь үүл ба хур тунадас дахь параметруудийн нөлөө;
  - Цаг агаарын өөрчлөлт;

- “Бүсийн ба Зам санаачилга” цаг уурын олон улсын хамтын ажиллагаа;
- Цаг уурын үйл ажиллагааны талбарууд
  - Бээжингийн цаг уурын станц
  - Цаг уурын архив
- Хаалтын хэсэг;
  - Оролцогчид санал, сэтгэгдлээ үлдээв. (Хичээлд оролцож буй зураг, бичлэгийн хамт)

4-р сарын 18-22-ны өдрүүдэд БНХАУ-ын Цаг уурын байгууллага болон ДЦУБ-ын Бээжин дэх бүсийн сургалтын төв (RTC-Beijing)-өөс цахим шууд хурал, хэлэлцүүлэг болсон бөгөөд уг хурлаар:

- ❖ Уур амьсгалын өөрчлөлтийн дотор онцгой болон аюултай үзэгдлийн эрсдэлийг удирдах. (Наньжины мэдээллийн шинжлэх ухаан, технологийн их сургуулийн профессор JIANG Tong удирдан явуулсан.)
- ❖ Дэлхийн уур амьсгалын эзлэх байр суурь ба уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг олон улсын үйл ажиллагаа. (Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний стратегийн судалгаа, олон улсын хамтын ажиллагааны төвийн Mr.GAO Xiang удирдан явуулав.)
  - Оролцогч нар шууд хичээлд идэвхтэй хамрагдсаныг зураг болон бичлэгийн хамт баримтжуулан илгээсэн.

Дүгнэлт: “Уур амьсгалын өөрчлөлт” хэмээх сэдэв нь маш өргөн цар хүрээтэй ба дэлхийн ихэнх улс орнууд эерэг арга хэмжээ авахаар их хэмжээний судалгаа шинжилгээ хийж харилцан уялдаатай хамтран ажиллах байна. Уг олон улсын цахим сургалтад хамрагдсанаар уур амьсгалын өөрчлөлт дэлхийн түвшинд хэрхэн явагдаж буй мөн түүний үр нөлөө байгаль экологи, нийгэм, эдийн засаг, болон бусад салбаруудад хэрхэн нөлөөлж буй түүний эсрэг авч болох арга, техникийн талаар тодорхой ойлголт авч, мэдлэг дээшлүүлсэн.

Тайлан бичсэн:

НЦУӨ-ний инженер

*З.Буян-Өлзий* · З.Буян-Өлзий